

ГЭХ № 01(01)

Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2010 оны 1 дүгээр сард 1624 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 129 хэргээр буюу 7.4 хувиар буурчээ (Зураг 1). Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (55), албан тушаалын эсрэг гэмт хэрэг (6), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (5), хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (5), захиргааны журмын эсрэг гэмт хэрэг (3) зэрэг хэрэг өмнөх оны мөн үеийнхээс нийтдээ 75-аар өссөн хэдий ч, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (162), нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (11), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг (11), байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг (5) буурсан нь нийт гэмт хэргийн тоо 129-өөр буурахад нөлөөлжээ.

Зураг 1



2010 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Баян-Өлгий аймагт 35.0 хувь, Увс аймагт 20.0 хувь, Орхон аймагт 18.2 хувь, Дорноговь аймагт 15.2 хувь, Завхан аймагт 12.5 хувь, Төв аймагт 6.0 хувиар өсч, Хэнтий аймагт 48.3 хувь, Баянхонгор аймагт 44.2 хувь, Говьсүмбэр аймагт 41.2 хувь, Өмнөговь аймагт 34.8 хувь, Ховд аймагт 33.3 хувь, Архангай аймагт 28.9 хувь, Өвөрхангай аймагт 27.8 хувь, Дундговь аймагт 23.1 хувь, Дорнод аймагт 20.8 хувь, Булган аймагт 16.7 хувь, Говь-Алтай аймагт 16.7 хувь, Сэлэнгэ аймагт 8.8 хувь, Дархан-Уул аймагт 8.5 хувь, Сүхбаатар аймагт 6.7 хувь, Хөвсгөл аймагт 4.0 хувь, Улаанбаатар хотод 2.7 хувиар буурчээ.

Энэ оны 1 дүгээр сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэргийн 20 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 7 хэргээр буюу 25.9 хувиар, малын хулгайн гэмт хэрэг 73 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 76 хэргээр буюу 51.0 хувиар буурсан байна.


Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 57.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 40.9 хувь нь аймгуудад, 1.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ. Бүртгэгдсэн гэмт хэргийн 49.2 хувийг хүндэвтэр, 40.8 хувийг хөнгөн, 8.5 хувийг хүнд, 1.5 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс хөнгөн хэргийн эзлэх хувь 6,2 пунктээр нэмэгдэж, хүндэвтэр хэргийнх 3.1 хувь, хүнд хэргийнх 2.4 хувь, онц хүнд хэргийнх 0.7 пунктээр буурсан байна (Зураг 2).

2010 оны 1 дүгээр сарын байдлаар 18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд улсын дунджаар 9 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1-ээр буюу 10.0 хувиар буурсан байна.

Энэ хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргээс сэжигтнээр тооцогдох этгээд нь тогтоогдоогүй байсан 548 хэргийн 178 буюу 32.5 хувийнх нь холбогдогч нь тогтоогдон яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 10.2 пунктээр, нийслэлийн хэмжээнд 11.3 пунктээр тус тус нэмэгдсэн байна (Зураг 3).


Зураг 2

Гэмт хэргийн ангилал, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар



Зураг 3

Гэмт хэргийн илрүүлэлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар



2010 оны 1 дүгээр сарын байдлаар гэмт хэрэгт холбогдсон 1259 сэжигтэн, яллагдагч байгаагийн 70 буюу 5.6 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 140 буюу 11.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 7.2 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа нь өмнөх оныхоос 1.9 пунктээр буурчээ.


Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад ажилгүй иргэдийн эзлэх хувь 2010 оны 1 дүгээр сарын байдлаар 62.2 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.6 пунктээр, оюутан, сурагчдын эзлэх хувь 6.9 болж, 0.5 пунктээр, албан хаагчийнх 6.9 болж, 0.7 пунктээр тус тус нэмэгдсэн бол ажилчин, малчдын эзлэх хувь 22.7 болж, 2.9 пунктээр буурчээ (Зураг 4).

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 4.1 хувиар нэмэгдэж, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 45.6 хувиар, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 17.8 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 10.6 хувиар буурчээ.

ГЭХ № 01(01)
Гэмт хэрэг


Зураг 4

Хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын
нийгмийн байдал, жил бүрийн 1 дүгээр сарын
байдлаар, хувиар



Зураг 5

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын
хэмжээ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар,
тэрбум төг



Улсын хэмжээнд 2010 оны 1 дүгээр сард 10.3 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 0,9 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 4916-аар буюу 32.3 хувиар, баривчлагдсан хүний тоо 500-аар буюу 36.4 хувиар буурчээ.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл 26.8 хувь нь гэр, орон сууцанд, 15.7 хувь нь гудамж талбайд, 9.1 хувь албан байгууллага, аж ахуйн нэгжид, 6.8 хувь нь баар, цэнгээний газар, зочид буудалд, 5.7 хувь нь бэлчээрт, 5.2 хувь нь нийтийн зах, дэлгүүрт, 30.7 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 2010 оны 1 дүгээр сард 611 хүн гэмтэж, 188 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 81-ээр буюу 11.7 хувиар буурч, нас барсан хүний тоо 5-аар буюу 2.7 хувиар нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2010 оны 1 дүгээр сарын байдлаар 1555.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 610.2 сая төг болж, өмнөх оны үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 4425.2 сая төг буюу 74.0 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 296.2 сая төг буюу 1.9 дахин өссөн байна (Зураг 5).

Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 1356.9 сая төг буюу 4.9 хувь нь хувийн өмчид учруулсан хохирол байна. Гэмт хэргийн улмаас нийт 1540 иргэн хохирсны 88 буюу 5.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 521 буюу 33.8 хувь нь эмэгтэйчүүд, 131 буюу 8.5 хувь нь хохирогчийн өөрийн буруугаас хохирсон иргэд байна.

Гэмт хэргийн улмаас нийт 59 байгууллагад хохирол учирсны 35 нь төрийн байгууллага, 21 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, 3 нь төрийн бус байгууллага байна.